

“ЛэндМН ББСБ” ХК



lendmn

2026

| Эхний хагас жилийн санхүү,  
үйл ажиллагааны тайлан



# Агуулга

"ЛэндМН ББСБ" ХК-ийн 2026 оны эхний хагас  
жилийн санхүү, үйл ажиллагааны тайлан

Бизнесийн үйл ажиллагаа

01

Санхүүгийн үзүүлэлтүүд

02

Онцлох үйл явдлууд

03

Эрсдэлийн удирдлага

04

Дотоод аудит

05

Компанийн засаглал

06



## БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

“ЛэндМН ББСБ” ХК (цаашид “ЛэндМН” гэх) нь технологид суурилан санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар Монгол Улсын эдийн засгийн гол хөдөлгөгч хүч болох бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан уян хатан, цогц экосистемийг бүрдүүлэн ажиллаж байна.

### FlexiBusiness: 100% дижитал, барьцаагүй зээлийн өсөлт

2026 оны эхний хагас жилд бид бизнесийн зээлийн багцыг нэмэгдүүлэхэд төвлөрч, LendMN аппликейшнээр дамжуулан “FlexiBusiness” барьцаагүй, дижитал зээлийн бүтээгдэхүүнийг 15,000 гаруй хувиараа бизнес эрхлэгчдэд олгоод байна. Тус бизнес эрхлэгчид ЛэндМН-ээс санхүүжилт авснаар 93% нь борлуулалтын орлогоо өсгөж, 38% нь шинээр ажлын байр бий болгосон эерэг үзүүлэлттэй байна.

### FlexiBusiness бүтээгдэхүүний тэлэлт: Компанид зориулсан зээлийн шугам

Бид хувь бизнес эрхлэгчдээс гадна жижиг, дунд компаниудад тулгардаг барьцаагүй, шуурхай санхүүжилтийн хэрэгцээг хангах зорилгоор 2026 оны 5 дугаар сард “FlexiBusiness” компанид зориулсан бүтээгдэхүүнээ албан ёсоор зах зээлд танилцууллаа. Компаниуд одоо <https://e-lend.mn> вэб сайтаар дамжуулан:

- Дансаа холбон зээлийн эрхээ шууд тооцоолуулах;
- Цаг хугацаа, орон зайнаас үл хамааран онлайнаар зээл авах;
- Эргэн төлөлтөө дижиталаар бүрэн шийдвэрлэх боломжтой болов.

Энэхүү шийдэл нь компаниудын эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийг шийдэхэд зарцуулдаг үнэтэй цаг хугацааг хэмнэж, бизнесээ дараагийн шатанд гаргахад нь бодит дэмжлэг болж байна.

### LendDy: Өдөр тутмын эргэлтийн хөрөнгийн төлбөрийн ухаалаг шийдэл

Бизнес эрхлэгчдийн эргэлтийн хөрөнгийн удирдлагыг хялбаршуулах зорилгоор бид LendDy “Хүссэнээ аваад, хүслээрээ төлөх” (BNPL) бүтээгдэхүүнийхээ цар хүрээг өргөжүүллээ. Бизнес эрхлэгч иргэн болон компаниуд өөрсдийн түрээс, тээвэр зэрэг өдөр тутмын эргэлтийн хөрөнгийн төлбөрүүдийг LendDy-ээр дамжуулан санхүүжүүлж, хүүгүй, шимтгэлгүйгээр хүссэнээрээ хуваан төлөх боломжийг бид бүрдүүлж байна.

Үүний нэгэн тод жишээ нь тээвэр, логистикийн салбарт тэргүүлэгч “Монложистикс Групп”-тэй хийсэн хамтын ажиллагаа юм. Уг түншлэлийн хүрээнд тээвэрлэлтийн зардлыг хүүгүй, шимтгэлгүйгээр хүссэнээрээ хуваан төлөх нөхцөлийг бизнес эрхлэгч харилцагчдадаа санал болгож эхэллээ. Бид ирээдүйд бизнес эрхлэгчдийнхээ түрээсийн төлбөр, бараа материалын татан авалт болон бусад үйл ажиллагааны зардлуудыг хамгийн хялбар бөгөөд оновчтой аргаар санхүүжүүлэх боломжуудыг тасралтгүй эрэлхийлж, хамтрагч байгууллагуудынхаа цар хүрээг нэмэгдүүлэхээр зорин ажиллаж байна.

# Flexibusiness

Компанид зориулсан зээл



Барьцаагүй

100%  
ДИГИТАЛ

100  
сая ₮




[www.e-lend.mn](http://www.e-lend.mn)



САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Санхүүгийн үзүүлэлтүүд өмнөх онуудын мөн үетэй харьцуулсан байдлаар





## 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

ЛэндМН нь 2026 оны эхний хагас жилд харилцагчид, бизнес эрхлэгчдэдээ тулгамдаж буй асуудлууд, хэрэгцээ шаардлагыг тодорхойлон бизнесээ дараагийн түвшинд гаргахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор нетворкинг арга хэмжээнүүдийг зохион байгуулж тэдний санал хүсэлтийг хүлээн авч цаашдын бүтээгдэхүүн хөгжүүлэлт, үйл ажиллагаандаа тусган ажиллахыг зорьж байна.



### Хувьцаа эзэмшигчдийн хурал

ЛэндМН нь 9 дэх удаагаа буюу 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 03-р сарын 28-ны өдөр амжилттай зохион байгууллаа.

Хуралд нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 81.65% нь оролцож, 5 асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэлээ.



### Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн арга хэмжээ

“Бизнесээ хамтдаа асаая” бизнес эрхлэгчдийн нэгдсэн арга хэмжээг 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр амжилттай зохион байгуулж 300 гаруй хувиараа бизнес эрхлэгчид оролцлоо.

Тэдгээр бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчид маань санхүү, борлуулалт, дижитал маркетинг зэрэг мэргэжлийн сургалтуудад хамрагдаж, ЛэндМН-ээс санал болгож байгаа шинэ, санхүүгийн шийдэл, бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар мэдээлэл аваад зогсохгүй хоорондоо танилцаж, шинэ түншлэл бий болгож, бизнесээ өргөжүүлж, борлуулалтын сувгаа нэмэгдүүлэх бодит боломжуудыг нэг дороос авлаа.

### НОГДОЛ АШИГ ХУВААРИЛЛАА

“ЛэндМН ББСБ” ХК 2025 оны ногдол ашгийг “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-д байршууллаа.

### Ногдол ашиг

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 02 сарын 06-ны өдрийн хурлаар нэгж хувьцаанд 16.5 төгрөг буюу Компанийн 2025 оны цэвэр ашгийн 30.4%, нийт 12,198,477,769.5 төгрөгийн ногдол ашгийг олгохоор шийдвэрлэсний дагуу 2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-р дамжуулан нийт хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны дансанд байршууллаа.



### “Money talks for Women” арга хэмжээ

Money Talks for women - “Эмэгтэйчүүдийн санхүүгийн өсөлт ба хөрөнгө оруулалт” арга хэмжээг “Райнос Инвестмент ҮЦК” ХХК-тай хамтран амжилттай зохион байгуулж, нийт 300 гаруй хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд:

- ЖДБ эрхлэгчдэд зориулсан санхүүгийн боломж, бизнес өсөлтийн шийдлүүд,
- Хөрөнгө оруулалтын боломжууд
- FlexiBusiness — хуулийн этгээдэд зориулсан дижитал, барьцаагүй бизнесийн зээлийн шинэ бүтээгдэхүүний танилцууллаа.



9 сая ам.долларын санхүүжилт

### 9 сая ам.долларын санхүүжилт

Бид бичил, жижиг дунд бизнес эрхлэгчдийнхээ санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх эрхэм зорилгынхоо хүрээнд 2026 оны 3 сард Сингапурын Helicap Income Opportunities Fund сангаас 9 сая ам.долларын санхүүжилт татан төвлөрүүлээ.




### “AI in E-Commerce” арга хэмжээ

“AI in E-Commerce: AI ашиглан хэрхэн борлуулалтаа өсгөх вэ?” арга хэмжээнд ЛэндМН нь ерөнхий ивээн тэтгэгчээр оролцож, цахим худалдаа эрхлэгчдэд зориулсан санхүүгийн шинэ боломжууд болон бизнесийн өсөлтийн шийдлүүдээ танилцуулж дэмжин ажиллалаа.




# ХАРИЛЦАГЧДЫН БИЗНЕСИЙН БОДИТ ӨСӨЛТ

ЛэндМН нь FlexiBusiness бүтээгдэхүүнээрээ дамжуулан санхүүжилт олгох замаар олон мянган бизнес эрхлэгчдээ дэмжин ажилласаар байна. 2026 оны эхний хагас жилийн байдлаар бизнес зээлийн нийт багцад эзлэх хувь 46.02%-д хүрч, 2025 оны хагас жилтэй харьцуулахад 19.22 нэгж хувиар өссөн үзүүлэлттэй байна.



Энэхүү тогтвортой өсөлт нь бидний Монгол Улсад **санхүүгийн тэгш хүртээмжийг нэмэгдүүлэх** эрхэм зорилгоо алхам алхмаар биелүүлж байгаагийн илрэл билээ. Бид олгож буй санхүүжилтийнхээ бодит үр нөлөөг харилцагчдын түвшинд системтэйгээр үнэлэх судалгааг 2025 оноос тогтмол хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2026 оны эхний хагас жилийн судалгааны үр дүнгээс харахад:

- Бизнесийн зээлийн харилцагчдын **48%** нь өмнө нь бизнесийн зориулалттай санхүүжилт огт авч байгаагүй.
- Харин бизнесийн санхүүжилт авч байсан харилцагчдын **42%** нь барьцаа хөрөнгө, нийгмийн даатгалын шимтгэлийн төлөлт зэрэг шаардлагын улмаас бизнесийнхээ хэрэгцээнд тохирсон, хангалттай хэмжээний санхүүжилт авч чаддаггүй байсан нь санхүүжилтийн хүртээмж хангалтгүй байсныг илэрхийлж байна.



Бизнес үзүүлсэн нөлөөллийн үр дүнгээс харвал:

- 93%** нь зээл авснаас хойш борлуулалтаа өсгөсөн ба үүнээс **76%** нь борлуулалтын орлогоо 30 хүртэлх хувиар өсгөсөн байна.
- 38%** нь 1-2 шинэ ажлын байр бий болгож, тэдний **69%** нь эмэгтэй ажилчид байна.

Эдгээр үр дүн нь бидний үйл ажиллагаа бизнес эрхлэгчдийн бизнесийн тогтвортой өсөлтийг дэмжих, шинэ ажлын байр бий болгох замаар Монгол Улсын эдийн засгийн идэвхжилд бодит хувь нэмэр оруулж байгааг илэрхийлж байна. Энэхүү судалгаа нь одоогоор зөвхөн FlexiBusiness бүтээгдэхүүний харилцагчдыг хамарсан бөгөөд цаашид бид шинээр нэвтрүүлсэн Компанийн зээлийн бүтээгдэхүүнд мөн адил хэмжилт, үнэлгээг өргөжүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.



ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

ЛэндМН нь Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй нээлттэй компанийн хувьд хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, харилцагчид болон хамтран ажиллагч нарынхаа итгэлийг хүлээж бизнесийн ёс зүйг эрхэмлэн ажиллаж, сайн засаглалын хүрээнд Эрсдэлийн Удирдлагын тогтолцоог бүрдүүлж ажиллаж байна.

Энэ хүрээнд олон улсын стандартын дагуу эрсдэлийн “Хамгаалалтын гурван бүс”-ийг тодорхойлон компанийн бүх нэгжүүдийн чиг үүрэг, төлөвлөгөө, гүйцэтгэлийн үнэлгээтэй уялдуулан ажилладаг.

| Хамгаалалтын 1-р бүс:                                                                                                                                                                                                                                                    | Хамгаалалтын 2-р бүс:                                                                                                                                                                                                        | Хамгаалалтын 3-р бүс:                                                                                                                                                       |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Бизнесийн болон тэдгээрт дэмжлэг үзүүлэх нэгжүүд хамаарахбөгөөдэрсдэлийг хариуцаж, удирдах эзэн буюу нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой гарахэрсдэлийг тодорхойлох, илрүүлэх, хариу арга хэмжээ авах, хяналтад байлгах, удирдах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. | Эрсдэл, хууль, хянан нийцүүлэлт хариуцсан нэгжүүд орох бөгөөд хамгаалалтын I бүсийн эрсдэлийн удирдлага, хяналтын зохион байгуулалт, үйл ажиллагаанд мониторинг хийх, заавар, зөвлөмжөөр хангах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. | Дотоод аудитын нэгж хэрэгжүүлэх бөгөөд хамгаалалтын II бүсийн тавьж буй хянан нийцүүлэлт, үнэлгээ, тайлагналын үр дүнтэй байдалд хараат бус үнэлэлт, дүгнэлт өгч ажилладаг. |

ЛэндМН нь Монгол улсын хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын дүрэм журмыг даган мөрдөж, тэдгээрийг үйл ажиллагаандаа нийцүүлснээр санхүүгийн үнэн зөв, ил тод тайлагнал, үйл ажиллагааны үр дүнтэй байдал, урт болон богино хугацааны стратегийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулахад байгууллагын ажилтан нэг бүрийн оролцоотойгоор хэрэгжүүлэх, тасралтгүй хөгжих системийг бий болгон ажиллаж байна.

Компани нь 2026 оны эхний хагас жилийн хугацаанд комплаенсийн эрсдэлийн удирдлагын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүллээ. Үүнд:

- Компанийн бизнесийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй компани болон эрх бүхий албан тушаалтны хооронд үүсэж болох аливаа ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хянах, үүссэн асуудлыг шийдвэрлэхтэй холбоотойгоор “Ашиг сонирхлын зөрчлийг мэдүүлэх журам”-ыг батлав.
- Мөнгө угаах гэмт хэрэг болон цахим залилангаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Монголбанкны Санхүүгийн мэдээллийн алба болон Цагдаагийн Ерөнхий газрын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газартай хамтран ажиллав.

ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ЛэндМН-ийн Дотоод аудитын алба нь Компанийн засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын тогтолцооны үр нөлөө, үр ашиг, оновчтой байдлыг бэхжүүлэхэд хараат бус, бодитой баталгаажуулалт болон зөвлөх үйлчилгээг үзүүлэх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэхийг зорин ажиллаж байна. Дотоод аудитын алба нь хараат бус аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлж, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороонд ажлаа шууд тайлагнадаг ба Гүйцэтгэх удирдлагыг шаардлагатай мэдээллээр ханган ажиллаж байна.

Дотоод аудитын алба нь Дотоод аудитын дэлхийн стандарт (Global Internal Audit Standards), COSO дотоод хяналтын хүрээ болон олон улсын тэргүүн туршлагыг үйл ажиллагааны үндсэн арга зүй болгон мөрдөж, байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцооны үр нөлөө, үр ашигт хараат бус, бодитой баталгаажуулалт, үнэлгээ хийж ажилладаг. Компанийн эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоог схемээр харуулбал:



Дотоод аудитын үйл ажиллагаа нь байгууллагын стратегийн зорилго, урт хугацааны тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэсэн үнэлгээ, сайжруулалтын санал зөвлөмжөөр дамжуулан удирдлагын шийдвэр гаргалтын чанарыг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Цаашид аудитын үйл ажиллагаанд мэдээллийн технологид суурилсан аргачлал, өгөгдлийн шинжилгээний хэрэглээг өргөжүүлэн, эрсдэлийг урьдчилан илрүүлэх болон урьдчилан сэргийлэх чадавхыг нэмэгдүүлэхэд анхааран ажиллаж байна.



КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

|                                                                   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
|-------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Оноосон нэр:<br>"ЛэндМН ББСБ" ХК                                  | МХБ-ийн хувьцааны бүртгэлийн ангилал:<br>I ангилал                                                                                                                                                                                                                                                                                                      |
| Хэлбэр:<br>Нээлттэй хувьцаат компани                              | Гаргасан нийт хувьцааны тоо ширхэг:<br>739,301,683                                                                                                                                                                                                                                                                                                      |
| Регистрийн дугаар:<br>5039754                                     | Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо:<br>14,845 (2026.05.31-ний өдрийн тархалтын судалгаагаар давхардсан тоогоор)                                                                                                                                                                                                                                              |
| Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага:<br>Монголын хөрөнгийн бирж | Үндсэн үйл ажиллагааны чиглэл:<br>1. Зээл олгох үйл ажиллагаа<br>2. Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах<br>3. Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх<br>4. Гадаад валютын арилжаа<br>5. Факторингийн үйлчилгээ<br>6. Итгэлцлийн үйлчилгээ<br>7. Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх<br>8. Төлбөрийн баталгаа гаргах |
| Үнэт цаасны код:<br>LEND                                          |                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ЛэндМН нь Монгол Улсын хууль тогтоомж болон Монголын хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй, нээлттэй хувьцаат компани болохынхоо хувьд Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж болон бусад зохицуулагч байгууллагаас баталсан холбогдох дүрэм, журам, засаглалын кодексыг үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг.

ЛэндМН нь зохистой засаглал, засаглалын тогтолцоог бэхжүүлэх, үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангахад онцгойлон анхаарч, улмаар Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, Удирдлагын баг болон бусад оролцогч талуудын хоорондох цогц харилцааг төгөлдөржүүлэх, засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн урт хугацаанд тогтвортой үнэ цэнийг бий болгохыг үргэлж зорьсоор байна.

ЛэндМН-ийн зүгээс хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч болон харилцагчдын эрх ашгийг хамгаалах, оролцогч талуудтай үр дүнтэй холбоо үүсгэх, санхүүгийн болон засаглалын мэдээллийг бүрэн бөгөөд үнэн зөв, цаг алдалгүй хүргэх зорилгоор үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэлийн талаар улирал, хагас жил, жилийн эцсийн хугацааг хамруулан мэдээлэх стратегийг баримтлан ажиллаж, тухай бүр тайлан бэлтгэж олон нийтэд хүргэдэг билээ.

Бид 2025 оны жилийн эцсийн тайланг 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдөр, 2025 оны БОНЗ-ын тайланг 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр, 2026 оны I улирлын тайланг 2026 оны 05 дугаар сарын 04-ний өдөр тус тус гарган олон нийтэд мэдээлснээр Компанийн

бизнес, засаглал, байгаль орчин, санхүүгийн үзүүлэлтүүд болон хэтийн төлөвийн талаарх мэдээллийг тухай бүр авах боломжийг хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, харилцагчид болон оролцогч талуудад олгож, харилцан итгэлцэл, эргэх холбоо бүхий хамтын ажиллагааг бий болгоход анхаарч ажилласан болно.

2026 оны хагас жилийн хугацаанд ЛэндМН-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гарсан тогтоолыг тухай бүр олон нийтэд нээлттэй мэдээлэн ажиллалаа.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ”) нь ЛэндМН-ийн үйл ажиллагааг бэхжүүлэх, зохистой түвшинд удирдах, засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг хэрэгжүүлэх, стратегийн зорилтдоо хүрэхэд ЛэндМН-ийг ерөнхий удирдлагаар хангаж, хяналт тавихын зэрэгцээ Гүйцэтгэх захиралд компанийн үйл ажиллагааг үр ашигтай, үр дүнтэй удирдахад нь шаардлагатай чиглэлийг өгч ажилладаг.

2026 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн ЛэндМН-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТУЗ-ийн ердийн 6, хараат бус 3 гишүүнийг сонгосон. ТУЗ-ийн ердийн 6 гишүүнээр Монгол Улсын иргэн О.Болдбаатар, Ц.Ууганбаяр, Б.Хос-Эрдэнэ, П.Отгонбаяр, С.Энх-Амгалан, Япон Улсын иргэн Кацухико Мадоно нар сонгогдсон бол ТУЗ-ийн Хараат бус 3 гишүүнээр Монгол Улсын иргэн С.Нэргүй, Х.Батсүрэн, Ц.Түмэнцогт нар тус тус сонгогдсон болно. Ийнхүү ТУЗ-ийн 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлаар ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн даргыг сонгож, ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн болон ТУЗ-ийн 2026 оны ээлжит хурлын хуваарь, ажлын болон сургалтын төлөвлөгөөг шинэчлэн баталлаа.

ТУЗ нь 2026 оны эхний хагас жилд 2 удаа ээлжит хурал, 5 удаа эчнээ санал хураалт явуулан нийт 33 тогтоол гаргажээ. ТУЗ-ийн тогтоолуудыг холбогдох журамд заасны дагуу Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр олон нийтэд нээлттэй мэдээлээд байна.

ТУЗ-ийн эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах зорилгын хүрээнд ЛэндМН-ийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тодорхойлсон, тодорхой чиг үүрэг, байнгын ажиллагаа бүхий 1) Эрсдэл ба БОНЗ-ын удирдлагын хороо, 2) Аудитын хороо, 3) Засаглал, нэр дэвшүүлэх хороо, 4) Цалин, урамшууллын хороод үйл ажиллагаа явуулж байна.



ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

| Эрсдэл ба БОНЗ-ын удирдлагын хороо<br>(цаашид “ЭБОНЗУХ”)                                                     | Аудитын хороо                                                |
|--------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------|
| О.Болдбаатар (ЭБОНЗУХ -ны дарга)<br>Б.Хос-Эрдэнэ, Ц.Ууганбаяр, Кацухико Мадоно,<br>С.Энх-Амгалан, Х.Батсүрэн | С.Нэргүй (Аудитын хорооны дарга)<br>Ц.Түмэнцогт, П.Отгонбаяр |

ЭБОНЗУХ нь 2026 оны хагас жилд нийт 2 удаа хуралдаж, ЛэндМН-ийн бизнесийн хөгжил, эрсдэл болон эх үүсвэрийн үйл ажиллагааны бодлогыг тодорхойлох, учирч болзошгүй эрсдэлийг оновчтой удирдан чиглүүлэхэд дэмжлэг үзүүлэх, нөхцөл байдалтай тухай бүр танилцан хэрэгжилтэд хяналт тавих болон БОНЗ-ын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна.

| Засаглал, нэр дэвшүүлэх хороо<br>(цаашид “ЗНДХ”)        | Цалин, урамшууллын хороо<br>(цаашид “ЦУХ”)           |
|---------------------------------------------------------|------------------------------------------------------|
| Х.Батсүрэн (ЗНДХ-ны дарга)<br>Ц.Түмэнцогт, О.Болдбаатар | Ц.Түмэнцогт (ЦУХ-ны дарга)<br>С.Нэргүй, О.Болдбаатар |

ЗНДХ нь 2026 оны хагас жилд нийт 1 удаа хуралдаж, ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчид тавигдах шаардлагыг тодорхойлж, шаардлага хангаж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, ердийн болон хараат бус гишүүдийг сонгон шалгаруулах, сонгох асуудлыг хэлэлцэж ажилласан байна.

Аудитын хороо нь 2026 оны хагас жилд нийт 2 удаа хуралдаж, ЛэндМН-ийн дотоод хяналтын тогтолцооны хэрэгжилтэд хяналт тавьж, дотоод аудиторын үйл ажиллагааны тайлантай тухай бүр танилцан шаардлагатай санал, зөвлөмжийг холбогдох албан тушаалтнууд болон ЛэндМН-ийн газар, хэлтэс, албадуудад өгч ажиллалаа. Түүнчлэн, ЛэндМН-ийн зүгээс хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар дүгнэлт гаргах, Компанийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байлгахад анхаарч мэдээллийг тухай бүр олон нийтэд хүргэж буй эсэхэд хяналт тавьж ажилласан байна.

ЦУХ нь 2026 оны хагас жилд нийт 1 удаа хуралдаж, ТУЗ-ийн 2026 оны төсвийн асуудлыг Компанийн ХЭЭХ-д танилцуулан шийдвэрлүүлэх асуудлыг хэлэлцэж ажилласан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн



**О.Болдбаатар**  
**ТУЗ-ийн дарга**  
Мэргэжил: Санхүүч, Аудитор,  
Олон улсын мэргэшсэн нягтлан бодогч  
АНД Глобал Пти.Лтд, Үүсгэн байгуулагч/  
ТУЗ-ийн гишүүн  
ОНДО ХХК, Үүсгэн байгуулагч/ТУЗ-ийн дарга



**Ц.Ууганбаяр**  
**ТУЗ-ийн ердийн гишүүн**  
Мэргэжил: Санхүүч  
АНД Дэнөүд ХХК, ТУЗ-ийн гишүүн  
ЛэндМН ББСБ ХК, Гүйцэтгэх захирал  
АНД ФСЖ Пти.Лтд, Гүйцэтгэх захирал  
АНД Системс ХХК, ТУЗ-ийн гишүүн  
АНД Системс ХХК, Гүйцэтгэх захирал  
Супер Ап Хэтэвч ХХК, Гүйцэтгэх захирал



**Б.Хос-Эрдэнэ**  
**ТУЗ-ийн ердийн гишүүн**  
Мэргэжил: Санхүүч, Бизнесийн удирдлага  
АНД Глобал Пти.Лтд,  
АНД Глобал Пти.Лтд, Гүйцэтгэх захирал  
АНД Глобал Пти.Лтд, ТУЗ-ийн гишүүн  
АНД ФСЖ Пти.Лтд, ТУЗ-ийн гишүүн  
АНД Сольюшн Пти.Лтд, ТУЗ-ийн гишүүн  
АНД Системс ХХК, ТУЗ-ийн дарга  
АНД Дэнөүд ХХК, ТУЗ-ийн дарга



**П.Отгонбаяр**  
**ТУЗ-ийн ердийн гишүүн**  
Мэргэжил: Программ хангамжийн  
инженер  
АНД Системс Тех ХХК, Гүйцэтгэх захирал  
АНД Глобал Пти.Лтд, ТУЗ-ийн гишүүн



**С.Энх-Амгалан**  
**ТУЗ-ийн ердийн гишүүн**  
Мэргэжил: Олон улсын харилцаа,  
олон улсын бодлого судлаач  
Мэргэн Инвестмент Пти.Лтд, ТУЗ-ийн гишүүн  
Монложистикс Холдинг ХК, ТУЗ-ийн гишүүн



**К.Мадоно**  
**ТУЗ-ийн ердийн гишүүн**  
Мэргэжил: Бизнесийн зөвлөх  
ЛэндМН ББСБ ХК, Ерөнхийлөгч  
Филиппин улс, Etomo Financing Corporation,  
Гүйцэтгэх захирал, Ерөнхийлөгч



**С.Нэргүй**  
**ТУЗ-ийн Хараат бус гишүүн**  
Мэргэжил: Санхүүч, Санхүүгийн мэргэшсэн зөвлөх  
“Сургалт үнэлгээ судалгааны хүрээлэн”  
Нийтэд үйлчлэх төрийн бус байгууллагын  
Захирал, Ахлах зөвлөх



**Х.Батсүрэн**  
**ТУЗ-ийн Хараат бус гишүүн**  
Мэргэжил: Хуульч



**Ц.Түмэнцогт**  
**ТУЗ-ийн Хараат бус гишүүн**  
Мэргэжил: Инженер, төслийн удирдлага  
болон эрчим хүч-уул уурхайн бодлого,  
хөрөнгө оруулалтын зөвлөх  
Монголын Бизнесийн Зөвлөл, ТУЗ-ийн дарга  
Дэлхийн Банк, Зөвлөх  
Азийн Хөгжлийн Банк, Бизнес  
хөгжүүлэлтийн чиглэлээр Дэд багийн ахлагч



ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ИРЦ, АЖИЛЛАСАН ХУГАЦАА БОЛОН БУСАД МЭДЭЭЛЭЛ

ЛэндМН-ийн ТУЗ-ийн гишүүд нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржийн холбогдох журам, кодекс, түүнчлэн ЛэндМН-ийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд аливаа шийдвэрийг хараат бусаар, бие даан гаргадаг. ТУЗ-ийн аливаа шийдвэр нь олонхын саналаар хүчин төгөлдөр болдог ба ТУЗ-ийн гишүүн нь хэлэлцэж буй асуудлаар “дэмжсэн”, “татгалзсан”, эсхүл “түдгэлзсэн” санал гаргах боломжтой. ТУЗ-ийн гишүүд нь тайлант хугацаанд ЛэндМН-ийн үйл ажиллагааг амжилттай эрхлэн явуулахад шаардлагатай, ач холбогдол бүхий шийдвэрүүдийг холбогдох баримт бичиг, судалгаа, тайлбар, дүгнэлттэй нэг бүрчлэн танилцсаны үндсэн дээр цаг алдалгүй гаргаж, чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна.

| ТУЗ-ийн гишүүд  | 2026 оны хагас жилийн ирц | ТУЗ-д ажилласан хугацаа, туршлага               | ЛэндМН-д хувьцаа эзэмшдэг эсэх |
|-----------------|---------------------------|-------------------------------------------------|--------------------------------|
| О.Болдбаатар    | 100%                      | ХЭЭХ-аас сонгогдож, 9 дахь жилдээ ажиллаж байна | Нийт хувьцааны 0.0079%         |
| С.Энх-Амгалан   | 100%                      | ХЭЭХ-аас сонгогдож, 9 дахь жилдээ ажиллаж байна | Нийт хувьцааны 0.09%           |
| Кацухико Мадоно | 100%                      | ХЭЭХ-аас сонгогдож, 3 дахь жилдээ ажиллаж байна | Нийт хувьцааны 0.0036%         |
| Ц.Ууганбаяр     | 100%                      | ХЭЭХ-аас сонгогдож, 5 дахь жилдээ ажиллаж байна | Нийт хувьцааны 0.0028%         |
| Б.Хос-Эрдэнэ    | 100%                      | ХЭЭХ-аас сонгогдож, 5 дэх жилдээ ажиллаж байна  | Үгүй                           |
| П.Отгонбаяр     | 100%                      | ХЭЭХ-аас сонгогдож, эхний жилдээ ажиллаж байна  | Үгүй                           |
| С.Нэргүй        | 100%                      | ХЭЭХ-аас сонгогдож, 3 дахь жилдээ ажиллаж байна | Үгүй                           |
| Х.Батсүрэн      | 100%                      | ХЭЭХ-аас сонгогдож, эхний жилдээ ажиллаж байна  | Үгүй                           |
| Ц.Түмэнцогт     | 100%                      | ХЭЭХ-аас сонгогдож, эхний жилдээ ажиллаж байна  | Үгүй                           |

ТУЗ-ИЙН ХУРЛЫН ТОГТООЛ, ТӨРӨЛ БОЛОН БУСАД МЭДЭЭЛЭЛ

| д/д | Шийдвэр гаргасан огноо      | Ирц  | Шийдвэр гаргасан хэлбэр | Баталсан тогтоолын тоо |
|-----|-----------------------------|------|-------------------------|------------------------|
| 1   | 2026 оны 02 дугаар сарын 06 | 100% | Ээлжит хурал            | 15                     |
| 2   | 2026 оны 03 дугаар сарын 17 | 100% | Эчнээ санал хураалт     | 1                      |
| 3   | 2026 оны 03 дугаар сарын 26 | 100% | Эчнээ санал хураалт     | 1                      |
| 4   | 2026 оны 04 дүгээр сарын 17 | 100% | Эчнээ санал хураалт     | 1                      |
| 5   | 2026 оны 04 дүгээр сарын 30 | 100% | Ээлжит хурал            | 12                     |
| 6   | 2026 оны 06 дугаар сарын 17 | 100% | Эчнээ санал хураалт     | 2                      |
| 7   | 2026 оны 06 дугаар сарын 29 | 100% | Эчнээ санал хураалт     | 1                      |

| Удирдлага зохион байгуулалт | Санхүү | Эрх олгох | Үйл ажиллагаа | Бизнес стратеги |
|-----------------------------|--------|-----------|---------------|-----------------|
| 6                           | 8      | 9         | 7             | 3               |

2026 оны хагас жилийн байдлаар Компанийн зээлийн үйл ажиллагааны өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй эрэлтийг хангах, үйл ажиллагааг санхүүжүүлэх үүднээс хоёрдогч өглөг авах болон Компанийн үйлчилгээг технологиор дамжуулан хүргэх, аппликейшний хөгжүүлэлт, засан сайжруулалтыг тогтмол хангахтай холбоотойгоор нийт 5 сонирхлын зөрчилтэй хэлцэлд ЛэндМН-ийн ТУЗ-өөс Монгол Улсын Компанийн тухай хуульд заасан журмын дагуу зөвшөөрөл олгогдож, эдгээр хэлцлийг байгуулан ажилласан байна.

“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ЫН ХЭРЭГЖИЛТ, ТҮҮНИЙ ҮНЭЛГЭЭ

ЛэндМН нь компанийн засаглал болон соёлыг сайжруулан бэхжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг үйл ажиллагаандаа тогтмол авч ажиллаж байгаа бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ний өдрийн 145 тоот тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан “Компанийн засаглалын кодекс”, түүний зарчмуудыг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар **95.74%**-тай хэрэгжүүлэн ажиллалаа. Санхүүгийн зохицуулах хорооны 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр олон нийтэд танилцуулсан нэгдсэн үнэлгээгээр ЛэндМН нь Монголын Хөрөнгийн Биржийн ТОП-20 компаниудаас засаглалын зэрэглэлээр гуравдугаар байранд буюу “Засаглал хэвийн буюу эрсдэлгүй” түвшинд үнэлэгдсэн байна. Бид 2026 оны үлдсэн хагаст Кодексын хэрэгжилтийг бүрэн хангахын тулд компанийн засаглалын ил тод байдлыг хангаж, ТУЗ-ийн ажлын болон сургалтын төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэн ажиллахад анхаарах болно.





**ВЕБСАЙТ:**

[www.lend.mn](http://www.lend.mn)

**УТАС:**

7707-0101

**ИМЭЙЛ:**

[board@lend.mn](mailto:board@lend.mn)